



I-VI/2022

Тархаасан: 2022 оны 8 дугаар сарын 12



Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2022 оны эхний хагас жилд 12.9 хувиар өслөө


Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2022 оны эхний хагас жилд 2.0 их наяд төгрөг болж, 1.9 (97.1%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 56.8 (2.9%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна. Барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 224.4 (12.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 216.6 (12.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

ХҮСНЭГТ 1. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, оны үнээр

	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022* I-VI	<u>2022* I-VI</u> 2021 I-VI
	тэрбум төгрөг				хувь
Нийт	2 068.5	2 294.2	1 735.6	1 960.0	112.9
Дотоодын байгууллага	1 954.4	2 269.2	1 686.6	1 903.2	112.8
Төрийн	56.8	184.7	235.0	54.1	23.0
Хувийн	1 888.7	2 066.4	1 429.8	1 832.6	128.2
Гадаадтай хамтарсан	8.8	18.1	21.8	16.5	75.5
Гадаадын байгууллага	114.1	25.0	49.0	56.8	115.9

Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 1.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 402.8 (28.2%) тэрбум төгрөгөөр өслөө. Харин төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 54.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 180.8 (77.0%) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 16.5 тэрбум төгрөг болж, 5.3 (24.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 1. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр




Харин барилга угсралт, их засварын ажлын (2015 оны зэрэгцүүлэх үнээр засварлан үнийн нөлөөллийг арилган тооцсон) гүйцэтгэлийн хэмжээ 1.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 35.0 (2.7%) төгрөгөөр буурчээ.

■ Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл

■ Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

ЗУРАГ 2. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, төрлөөр, тэрбум төгрөг



Энэ оны эхний хагас жилд барилга угсралт, их засварын ажлын 48.8 хувийг орон сууцны барилга, 35.4 хувийг орон сууцны бус барилга, 12.7 хувийг инженерийн барилга, байгууламж, 3.1 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 9.7 нэгж хувиар, их засварын ажил 0.9 нэгж хувиар өссөн бол инженерийн барилга, байгууламжийнх 10.4 нэгж хувиар, орон сууцны бус барилгынх 0.2 нэгж хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 2. ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, төрлөөр

Барилгын төрөл	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022* I-VI	<u>2022* I-VI</u> 2021 I-VI
	тэрбум төгрөг				хувь
Орон сууцны бус барилга	1 001.7	885.5	618.0	694.8	112.4
Үйлдвэрийн	574.0	357.5	334.8	296.9	88.7
Худалдаа, үйлчилгээний	60.0	68.1	56.1	83.1	148.1
Эмнэлгийн	59.1	40.6	23.5	26.7	113.5
Сургууль, соёлын	199.3	246.0	121.2	152.4	125.8
Бусад	109.3	173.4	82.4	135.7	164.8

Орон сууцны бус барилгын ажил 2022 оны эхний хагас жилд 694.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 76.8 (12.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд үйлдвэрийн барилгын ажил 37.9 (11.3%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч сургууль соёлын барилгын ажил 31.2 (25.8%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгын ажил 27.0 (48.1%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 53.3 (64.8%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 3.2 (13.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 3. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, тэрбум төгрөгөөр



Улаанбаатар хотод 2022 оны эхний хагас жилд 1.1 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 56.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 8.6 нэгж хувиар өссөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 348.5 тэрбум төгрөг, Орхон аймагт 83.2 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын

барилга угсралтын ажлын дүнд 52.2 хувийг эзэлж байна. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил төмөр зам болон автозамын ажлууд, Ховд аймагт цементийн үйлдвэрийн барилга, угсралтын ажил, Орхон аймагт Эрдэнэт үйлдвэрийн барилгын өргөтгөлийн ажил, орон сууцны барилгын ажлууд эрчимтэй явагдсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Барилга угсралт, их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

Орон сууцны барилга нь хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.

Орон сууцны бус барилгад барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%-иас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.

Инженерийн барилгын ажилд төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга байгууламжийн бүх ажлыг оруулна.



Тайлбар: ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр:

ҮСХ, Барилга байгууламж, объектын улирлын мэдээ (ББО-1)

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 11 дүгээр сарын 12

Эдийн засгийн статистикийн газрын дарга
А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө
аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн
статистикийн хэлтсийн статистикч
Л.Шинэтуяа
Утас : (976-51)-261563

